



НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2009 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Г Томилолтоор ажиллуулах тухай


Нийслэлийн Засаг даргын 2009 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн 26.6 дугаар заалт болон ӨМӨЗО-ны Хөх хотын Биеийн тамир, спортын газрын урилгыг үндэслэн **ТУШААХ НЬ**:

Нэг. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот, ӨМӨЗО-ны нийслэл Хөх хотуудын уламжлалт харилцааны дагуу харилцан туршлага судлах, цаащдын хамтын ажиллагааныхаа чиглэлийг өргөжүүлэх зорилгоор урьдчилан тохиролцсоны дагуу дараахи бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийг 2009 оны 04 дүгээр сарын 14-17-ны өдрүүдэд Хөх хотод ажлын айлчлал хийлгэхээр томилон ажиллуулсугай. Үүнд:

- | | |
|-------------------|----------------------------------------------------------------------------------|
| 1. А.Болдмаа | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын ахлах мэргэжилтэн /Төлөөлөгчдийн ахлагч/ |
| 2. О.Болор-Эрдэнэ | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн |
| 3. Ж.Цэдэнсодном | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын нягтлан бодогч |
| 4. Ш.Бямбасүрэн | Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга |
| 5. Ж.Болдбаатар | Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга |
| 6. С.Баасанжав | Налайх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга |
| 7. М.Алтангэрэл | Сүхбаатар дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга |
| 8. Ц.Ганболд | Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга |
| 9. А.Хоролсүрэн | Сүхбаатар дүүргийн Биеийн тамир, спортын хорооны ахлах мэргэжилтэн |

Хоёр. Ажлын айлчлалын удирдамжийг хавсралтаар баталсугай.

Гурав. Ажлын айлчлалын тайланг ирсэн өдрөөс хойш ажлын 3 едрийн дотор тайлاغнахыг төлөөлөгчдийн ахлагч /А.Болдмаа/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Ж.ГАНБОЛД

050010

62
47

НБТСГ-ын даргын 2009 оны 04 дугаар сарын
09-ны өдрийн 19 дугаар тушаалын хавсралт

УХЫН СОХЧА

ӨМӨЗО-НЫ ХӨХ ХОТОД ТОМИЛОЛТООР АЖИЛЛУУЛАХ УДИРДАМЖ

- Хөх хотын Даргын Нийгмийн асуудал хариуцсан Орлогч даргатай уулзах;
- Гудамж талбайн усан оргилууруудыг үзэж сонирхох, байгуулж байгаа технологи, арга хэлбэртэй танилцах;
- Хөх хотын Биеийн тамир, спортын хорооны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, санхүүжилтийн тогтолцоотой танилцаж, туршлага судлах;
- Нийтийн Биеийн тамирыг хот, дүүрэг, хороодод зохион байгуулж байгаа хэлбэр, санхүүжилтийн тогтолцоотой танилцах;
- Нийтийн Биеийн тамир, спортын чиглэлээр хүн амын дунд үйлчилгээ хийдэг спортын клуб, байгууллагын үйл ажиллагаатай танилцах;
- Хоёр хотын дүүргүүдийн Биеийн тамир, спортын хороодыг хамтын ажиллагаатай болгох;
- Боломжтой спортын төрлөөр баг тамирчид, төлөөлөгчдөө солилцон хамтарсан бэлтгэл хийх, уралдаан тэмцээнд оролцох талаар харилцан тохиролцох;
- Спортын төрөлжсөн дунд сургуулийн үйл ажиллагаатай танилцах.